

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ
6 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл
ажиллагааны мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 6 дугаар сард удаа хуралдаж төрийн дээд цол, одон медальд тодорхойлох, өмчийн тухай, аймгийн баяр наадмыг товлон зарлах, зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг томилох зэрэг 9 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Үндсэн хуулинд оруулах өөрчлөлтийн талаархи хэлэлцүүлгийг Төвшрүүлэх, Цэнхэр, Эрдэнэбулган сумдад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас УИХ-ын гишүүд, аймгийн удирдлагуудтай хамтран зохион байгуулж хэлэлцүүлэгт аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, төрийн албан хаагчид, иргэд идэвхтэй оролцож санал бодлоо илэрхийлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

2019 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт 144.915.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 54 төсөл арга хэмжээ хэрэгжинэ. Үүнээс 2019 онд 42.262.3 сая төгрөгөөр санхүүжинэ. Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалалтаар 5 төсөл арга хэмжээнд 275.6 сая төгрөг батлагдсанаас 4 төсөл арга хэмжээ нь шинээр хэрэгжих 1 төсөл арга хэмжээ нь урд оны дутуу санхүүжилт байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 7.302.6 сая төсөвт өртөг бүхий 26 төсөл арга хэмжээ хэрэгжинэ. Үүнээс 2019 онд 3.011.6 сая төгрөгөөр санхүүжинэ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3 төсөл арга хэмжээнд 132.7 сая төгрөг үүнээс барилга байгууламж 120.0 сая төгрөг, тоног төхөөрөмж 12.7 сая төгрөг тус тус тусгагдаад байна.

Аймгийн удирдах ажилтны ээлжит шуурхай зөвлөгөөнийг 6-р сарын 25-ны өдрийн 10.00 цагт аймгийн ЗДТГ-ын VIP танхимд зохион байгуулж аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ээс 2019 оны 5-р сарын 30-ны өдрийн шуурхай зөвлөгөөний үеэр аймгийн Засаг даргаас өгсөн 5 үүрэг даалгаврын биелэлтийн явцыг танилцуулж, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтсээс цаг үеийн болон үйл ажиллагааны талаар мэдээлэл хийв.

Энэ удаагийн зөвлөгөөнөөр аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаас цаашид эрчимжүүлж, сайжруулах ажил арга хэмжээний талаар 9 төрлийн үүрэг даалгаврыг байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт өглөө.

Батлан хамгаалахын сайдын 2019 оны А/165 дугаар тушаалаар томилогдсон цэргийн эмч нарын комисс 6-р сарын 22-ны өдөр Архангай аймагт ажиллаж, цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн асуудлаар аймгийн нутгийн захиргааны болон эрүүл мэндийн байгууллагын удирдлага, цэрэг татлагын товчооны эмч, цэргийн алба хаах насны залуучуудтай сургалт, семинар явуулахын зэрэгцээ цэргийн жинхэнэ

албанд эрүүл мэндийн байдлаар тэнцэхгүй шалтгаантай иргэдэд эрүүл мэндийн үзлэг хийж хугацаат цэргийн албанаас чөлөөлөх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт ажиллаж, эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын комиссын дүгнэлт гаргуулсан 81 иргэдийн материалыг хүлээн авч эрүүл мэндийн үзлэг хийснээс Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолын 5 дахь хавсралтад заагдсан өвчин эмгэгийн улмаас тайван цагт цэргийн жинхэнэ албанаас эрүүл мэндээр чөлөөлөгдөх 36 иргэнийг чөлөөлж, халагдах заалтгүй 16 иргэний материал дутуу, шинжилгээ бүрдүүлэх шаардлагатай 29 иргэнийг үзлэгээр оруулж ажилласан байна.

“Төлөвлөлт хяналт-шинжилгээ, үнэлгээний уялдаа холбоог хангах нь” сэдэвт Хангайн болон Төвийн бүсийн аймгуудын нэгдсэн сургалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газраас аймгийн ЗДТГ-тай хамтран 2019 оны 6 дугаар сарын 6-9-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар “Төлөвлөлт хяналт-шинжилгээ, үнэлгээний уялдаа холбоог хангах нь” төвийн болон хангайн бүсийн аймгуудын сургалтыг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон бэлтгэл ажлыг ханган, сургалтыг амжилттай зохион байгуулсан ба сургалтад аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан 19 албан хаагч, 18 сумын ЗДТГ-ын дарга, 13 нутгийн захиргаа эрх зүйн ажилтан болон бусад төрийн албан хаагчид нээлттэй оролцсон бөгөөд аймгаас нийт 60 гаруй төрийн албан хаагч оролцож мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн байна. Энэ бүсийн зөвлөгөөнд хангайн болон төвийн бүсийн Нийслэл, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын дарга нар болон хэлтсийн дарга нар, мэргэжилтнүүд зэрэг нийт 100 хүн хамрагдлаа.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан аймгийн салбар комисс байгуулж, байгууллага бүр үзлэгт бэлтгэх комисс байгуулан бэлтгэл ажлыг хангаж ажиллалаа.

Аймгийн салбар комиссоос урьдчилсан үзлэгийг нийт 7 сумын ЗДТГ, 42 байгууллагад хийж илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж нийт байгууллага, сумдад зөвлөмж өгч ажилласны үр дүнд 6-р сарын 12-16-ны өдрүүдэд Архангай аймагт ажилласан улсын үзлэгээр **90,7 оноо** буюу “**Маш сайн**” үнэлгээтэй амжилттай дүн үзүүлээ.

Төрийн тахилгат Суварга хайрхан уулын тэнгэрийг тайх ёслол-4 жил тутамд болдог төрийн тахилгын арга хэмжээг ажлын хэсэг томилогдон удирдамж, төлөвлөгөөний дагуу 2019 оны 6 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулалтын өндөр түвшинд, “Байгаль орчноо хамгаалай” уриан дор тэмдэглэн өнгөрүүлээ. Ёслолын арга хэмжээний хүрээнд 2 насны хурдан морины уралдаан, 64 бөхийн барилдаан, үндэсний сурын харваа, шагайн харвааны тэмцээнийг зохион байгуулсан.

Төрийн албан хаагчдыг ажлын байран дээр нь чадавхжуулах зорилгоор Удирдлагын Академийн багш нарыг урьж 2019 оны 6 дугаар сарын 22-ны өдөр аймгийн ЗДТГ-т төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны чиг үүргийн шинжилгээ, албан тушаалын тодорхойлолт, албан хэрэг хөтлөлт, төрийн албан хагчийн манлайлал, төрийн байгууллагад хяналт-шинжилгээ, үнэлгээний арга

зүйг хэрэглэх нь сэдвүүдээр сургалт зохион байгуулж 70 гаруй төрийн албан хаагчийг хамрууллаа.

Аймгийн Онцгой байдлын газрын гал унтраах 51-р ангийн түүхт 50 жилийн ойг 6 дугаар сарын 28-ны өдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Ойн арга хэмжээний үеэр "Онцгой байдлын тэргүүний ажилтан", "Онц гал сөнөөгч", УОК-ын "Хүндэт тэмдэг"-ээр нийт 7 алба хаагч, ОБЕГ-ын жуух, баярын бичиг, сайшаалын үнэмлэх, "Онцгой байдлын албаны төлөө" тэмдгээр 12 алба хаагч, аймгийн ИТХТ-дийн "Хүндэт тэмдэг"-ээр 3, Засаг даргын жуух бичгээр 5, аймгийн "Хүндэт тэмдэг"-ээр 1, "Хүндэт өргөмжлөл"-өөр 3, Монголын Залуучуудын холбооны шагналаар 8 алба хаагчийг тус тус шагнаж урамшуулсан байна.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

Татвар төлөлтийн талаар

6 дугаар сард хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 100.0 хувьтай байна.

Тайлант хугацаанд 5-р сарын нэмэгдсэн ертгийн албан татварын 215 тайлан цахимаар хүлээн авч тайлангийн ирцийг 98.1 хувьтай хангуулж, шалгуур үзүүлэлт хангаагүй байцаагчид хуваарилагдсан 22 тайланг тайлан хүлээн авах журмын дагуу хүлээн авч баталгаажууллаа.

Тайлант хугацаанд 36 иргэн, аж ахуйн нэгжид тендерт оролцох виз хүссэн, зээл авах, бусад төрлүүдээр лавлагаа тодорхойлолт гаргаж, цахимаар ирүүлсэн тайлан засварлах, хуулийн хугацаа сунгуулах, тоон гарын үсэг авах зэрэг 138 хүсэлтийг тайс системээр хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд нэг цэгийн өрөөгөөр давхардсан тоогоор 70 гаруй иргэнд зөвлөгөө өгсөн байна.

Санхүүгийн хяналтын чиглэлээр

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд батлагдсан удирдамжийн дагуу Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг сумдын төсөвт албан газрууд, Орон нутаг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сангийн 2017-2018 оны үйл ажиллагаанд аудит, хяналт шалгалтыг улсын байцаагчийн хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийн хүрээнд хийж гүйцэтгэлээ. Аудит, хяналт шалгалтаар улсын байцаагчийн 29 төрлийн актаар 35.7 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, үүнээс ажилтан албан хаагч нарт дутуу олгосон цалин хөлс, ээлжийн амралтын олговор, үр дүнгийн урамшууллын 16.0 сая төгрөгийг нөхөн олгуулах, 19.7 сая төгрөгийг аймаг, орон нутгийн төсвийн орлогод хураан барагдуулахаар тус тус шийдвэрлэлээ.

Мөн тус сумдын сум хөгжүүлэх сан болон бусад үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчлийг арилгуулахаар 355.6 сая төгрөгийн дүн бүхий улсын байцаагчийн 6 албан шаардлагаар хугацаатай үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны чиглэлээр

Орон нутгийн өмчит 56 төсөвт байгууллагад 187.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 2 төсөвт байгууллагад 70 нэрийн 9.3 сая төг-ийн өртөг бүхий үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрлийг тус тус олгосон байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчийн хурлаар 17 асуудал оруулж, актлаж устгах 10,

нэг байгууллагаас нөгөө байгууллагад шилжүүлэх 4, бусад асуудлаар 3 тогтоол гарсан байна.

2019 оны 6 дугаар сард Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Тариат сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөл /500.000.000 төгрөг/, Оюутны байрны барилга /Архангай, Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хайрхан, Хотонт, Эрдэнэмандал сум/ 600.000.000 төгрөг, аймгийн мал эмнэлэгийн байр /100.000.000 төгрөг/, эмнэлэгийн тусламж үйлчилгээнд хэрэглэгдэх жирэмснээс хамгаалах, эм эмнэлэгийн хэрэгсэл нийлүүлэх /33.582.380 төгрөг/, Цэцэрлэг хотын доторхи хайрган, хатуу хучилттай авто замын засвар арчлалт, техникийн шинэчлэл /80.000.000 төгрөг/, Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн /500.000.000 төгрөг/, Жаргалант сумын сургуулийн өргөтгөлийн барилга /1.000.000.000 төгрөг/, Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах урсцыг сайжруулах /4.000.000.000 төгрөг/, нийт 6.813.582.3 төгрөгний худалдан авалтын ажлын тендерийг зарлан зохион байгуулсан.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Иргэний бүртгэлийн чиглэлээр

Шинээр төрсөн хүүхдээ бүртгүүлсэн төрөлт – 159
Гэрлэлтийн бүртгэл - 57
Гэрлэлт цуцалсаны бүртгэл - 1
Хүүхэд үрчлэлтийн бүртгэл – 2
Эцэг тогтоосны бүртгэл -5
Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсөний бүртгэл - 12
Нас баралтын бүртгэл - 50
Шинээр иргэний үнэмлэх олгосон - 154
Дахин олгосон - 110
Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 278
Үндэсний энгийн гадаад паспорт- 39
Шилжилт хөдөлгөөн-152
Иргэнд - 450 лавлагаа
Хóóëü öÿíàèòóí ààéáóóëèàààà - 40 èààëàãàà

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр

Газар өмчлөх эрхийн анхны бүртгэл – 59
Үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл - 10
Шинээр бүртгүүлсэн орон сууцны бүртгэл – 1
Газар эзэмших эрхийн анхны бүртгэл – 0
Арилжааны гэрээ – 0
Худалдах худалдан авах гэрээ – 52
Бэлэглэлийн гэрээ – 10
Барьцааны эрхийн бүртгэл –291
Өв залгамжлал – 5
Хамтран өмчлөгч өөрчлөгдөх – 7
Лавлагаа – 3

Бусад эрхийн бүртгэл – 3

Хóóëü öýíàëòüí áàéáóóëëáááá íëéò 14 ëàáëááááá áàðááí ò¿ðã¿¿ëñýí áàéíà. Дээрх бүртгэлүүдийг хийж улсын төсөвт үйлчилгээний хөлс 3498595 төгрөг, тэмдэгтийн хураамжид 30042 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсанаас оруулсан татварын орлого 7006000 төгрөг төвлөрүүлсэн байна.

Хуулийн этгээдийн чиглэлээр

Шинэ-10

Өөрчлөлт-11

Тамга тэмдэгний хяналтын дугаар олгосон-13

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Хүүхдийн баяр угтсан урьдчилан сэргийлэх шалгалтанд 48 объектод хяналт шалгалт хийж, 69 зөрчил илрүүлэн 53.2 %-ийг арилгуулан, 10 объектод 1400 мянган төгрөний торгуулийн арга хэмжээ авлаа. Шалгалтаар чанар аюулгүй байдлын шаардлага хангахгүй, хадгалах хугацаа хэтэрсэн, шошгын зөрчилтэй 113 нэр төрлийн /731 ширхэг, 47.5 кг, 136 л/ 3.6 сая төгрөгний хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг хураан авч сумын ЗДТГ-ын комисст шилжүүллээ.

Аймгийн төвийн 60 айл өрхийн 106 хүүхэд, МСҮТ-ийн дотуур байр, хүнсний зах, цэцэрлэгт хүрээлэн зэрэг газруудаас 30 хүүхэд, Тариат сумын Суман багийн 30 өрхийн 54 хүүхдийн дархлаажуулалтын байдлыг газар дээр нь шалгаж, вакцинд хамрагдаагүй нийт 7 хүүхдийг харъяа сум, өрхийн эмнэлэгт мэдээллэн 5 хүүхдийг вакцинд хамрууллаа. Эрдэнэбулган суманд улаанбурханы нэмэлт дархлаажуулалт 97.9%, Тариат суманд 98.2%-тай хийгдсэн байна.

Шүүхийн шинжилгээний албанаас 6-р сард криминалистикийн шинжилгээ 1, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримт 58, шүүх эмнэлгийн шинжилгээ 46, тусгай шинжилгээ 23-ыг тус тус хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 6-р сард гамшиг осол, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын дуудлага нийт 7 удаа ирснээс, объектын гал түймрийн дуудлага 1, галын зөрчлийн дуудлага 6 удаа тус тус ирсэн байна.

Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, норм, стандарт зөрчсөн, гал түймэр гарч болзошгүй 124 зөрчил илрүүлэн, газар дээр нь 12 зөрчлийг арилгуулж бусад зөрчлийг арилгуулахаар заавал биелүүлэх албан шаардлага 8, мэдэгдэл 4-ийг тус тус хүргүүлэн 89 зөрчил дутагдлыг гүйцэтгэлийн хяналт шалгалтаар арилгуулсан байна.

Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 1952386 төгрөгийн мөнгөн дүн бүхий 463 гүйцэтгэх баримт бичиг ирснээс шийдвэр гүйцэтгэх бодит биелэлтийн хувь 37.4, мөнгөн дүнгийн дундаж үзүүлэлт 21.4 байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Боловсролын чиглэлээр

Засгийн газрын 2008 оны 293 дугаар тогтоолоор баталсан “Англи хэлний үндэсний хөтөлбөр”, 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”, 2019 оныг “Хүүхэд хамгааллын жил” болгон зарласан аймгийн Засаг даргын 2019 оны а/01 дүгээр захирамж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 27 дугаар тогтоолоор баталсан багшийн хөгжлийг дэмжих

“Багшийн хөгжил” аймгийн дэд хөтөлбөр, мөн 28 дугаар тогтоолоор баталсан хүүхдийн хөгжлийг дэмжих “Ирээдүй 1+1” аймгийн дэд хөтөлбөр, Швейцарийн санхүүжилтээр БСУГ-т хэрэгжсэн “Тогтвортой хөгжлийн боловсрол” төсөл зэрэг хүүхдийн эрх хамгаалал, хөгжил оролцоог дэмжсэн бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд “Тогтвортой хөгжил-ногоон ирээдүй” уриан дор “Англи хэл-амьдрах чадвар” хүүхдийн зуны сургалтыг БСУГ-ын даргын санаачилгаар 2 дахь жилдээ зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга “Ирээдүй 1+1” дэд хөтөлбөрийн хүрээнд Хөгжимт драмын театр болон Ерөнхий боловсролын 9 сургуульд нийт 26.2 сая төгрөгний морин хуур, ятга, лимбэ, шанз, ёочин зэрэг 95 ш үндэсний хөгжмийг гардууллаа.

2019 оны 5, 9, 12 ангиудын төгсөх ангийн Улсын шалгалтын үйл ажиллагаа 2019 оны 5-р сарын 27-оос эхэлж, хуваарийн дагуу явагдаж 6-р сарын 06-ны өдөр дууссан. Шалгалтуудын блюпринт, даалгаврын сан нь Боловсролын үнэлгээний төвийн <http://itembank.eec.mn/> сайтад бага боловсролын 3 хичээлээр нийт 1875 даалгавар, суурь боловсролын 10 хичээлээр 5888 даалгавар, бүрэн дунд боловсролын 10 хичээлээр 6780 даалгавруудаас сонгон аймгийн хэмжээнд 5-р ангийн 1756 суралцагч монгол хэл, математик, хүн байгалийн хичээлээр, 9-р ангийн 1339 суралцагч /дүйцсэн/ монгол хэл, математик, гадаад хэл, сонгох хичээлээр, 12-р ангийн 535 суралцагч /дүйцсэн/ монгол хэл, математик, гадаад хэл, сонгох хичээлээр тус тус шалгагдлаа.

Соёл урлагийн чиглэлээр

Аймгийн Нийтийн номын сан нийтийн уншлагын танхимаар 33 уншигч шинээр бүртгэж, 1738 ирэгсэдэд 1000 ном, 476 сонин, сэтгүүлээр, хүүхдийн уншлагын танхимаар 6 уншигч шинээр бүртгэж, 1669 ирэгсэдэд, 3045 номоор, гэрээр ном олгох үйлчилгээгээр 84 ирэгсэдэд 170 ном, 24 ширхэг сонин олгож үйлчилсэн байна.

Эрүүл мэндийн чиглэлээр

2019 оны эхний 5 сарын байдлаар 688 эх төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 42 төрөлтөөр буюу 9,4 хувиар буурсан байна. Нийт төрөлтийн 80.8 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 15,1 хувь нь сумын эрүүл мэндийн төвүүдэд, 4,0 хувь нь сум дундын эмнэлэгт тус тус төрсөн байна. Нэгдсэн эмнэлэгт төрсөн эхийн – 195 буюу 35 хувь нь ЭБ сумын харъяат эзэлж байна. Аймгийн хэмжээнд 2019 оны эхний 5 сарын байдлаар нийт 145032 үзлэг хийгдсэнээс 57248 буюу 39.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд эхний 5 сарын байдлаар 5 хүртэлхи насны хүүхдийн эндэгдлийн 13 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 18,8 ноогдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 тохиолдлоор буюу 1000 амьд төрөлтөд 8.8-аар буурсан байна.

Аймгийн хэмжээнд эхний 5 сарын байдлаар халдварт өвчний нийт 224 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнтэй ижил түвшинд байна.

Цочмог халдварт өвчин 92 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 14 тохиолдлоор буурсан. Архаг халдварт өвчин 132 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 14 тохиолдлоор нэмэгдсэн байна.

ЭМГ-ын даргын 2019 оны А/68 тоот тушаалаар 7 суманд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг зохион байгуулж, 723 хүнийг үзлэг, шинжилгээнд хамруулж, бэлгийн замаар дамжих халдварын 24 тохиолдлыг илрүүлж эмчилгээнд хамруулсан. Сүрьеэгийн сэжигтэй 12 тохиолдлоос сорьц авч аймгийн Нэгдсэн эмнэлэг рүү шилжүүлсэн байна.

“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2-12 насны хүүхдийн шүдийг улсын төсвөөр эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг “Тана-Арцат” эмнэлэг зохион байгуулж, 2-12 насны нийт 371 хүүхдийг үзлэг, эмчилгээнд хамруулж, бүрэн эрүүлжүүлсэн.

Өсвөр үеийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийн асуумж судалгааг аймгийн төвийн 5 сургуулийн 9-12 дугаар ангийн 404 хүүхдийг түүвэрлэн авсан. Судалгааг эрүүл ахуйн дадал хэвшил, осол гэмтэл, сэтгэцийн эрүүл мэнд, архи, тамхины хэрэглээ, нөхөн үржихүйн эрүүл мэнд, ХДХВ/ДОХ, цахим хэрэглээ гэсэн чиглэлээр авч, дүгнэлт зөвлөмж гаргасан

Биеийн тамир, спортын чиглэлээр

Зуун буудалт даамын сонирхогчдын Улсын аварга шалгаруулах тэмцээнийг 6 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд Архангай аймагт зохион байгууллаа. Тэмцээнд 14 аймгийн 196 даамчин гурван өдрийн турш эрэгтэй, эмэгтэй ангилалын үндсэн болон рапид тэмцээний төрөлд оюун ухаан, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн юм. Эрэгтэй даамчдын үндсэн тоглолтын тэмцээнд Говьсүмэр аймгийн харьяат спортын дэд мастер Ё.Бат-Өлзий, рапид тэмцээнд УБ хотын харьяат, спортын мастер н.Ганбаатар түрүүлсэн бол эмэгтэйчүүдийн үндсэн болон рапид тэмцээнд Архангай аймгийн харьяат, спортын дэд мастер П.Сурмаасүрэн түрүүлжээ.

Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагын албан хаагчид, багийн иргэдийн эрүүл мэндийг идэвхтэй хөдөлгөөнөөр дэмжих, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, дасгал, явган алхалт хийдэг иргэдийн тоог нэмэгдүүлэх, байгууллагуудын идэвхи оролцоог сайжруулах, идэвхтэй алхалтын ач холбогдлыг сурталчлах зорилгоор “Өдрийн эрч хүчийг өглөөний нарны алхалтаас” уриан дор явган алхалтын аяныг 2019 оны 5 сарын 01-31-ний хооронд зохион байгуулсан. Сарын турш өглөөний алхалт дасгалд 65 байгууллагын давхардсан тоогоор 2336 хүн хамрагдсан байна. 2019 оны 6 дугаар сарын 02-ны өдөр Алхалты аяны дүнг сарын турш алхсан ажилчдын ирц, хуваарьтай өдөр алхсан ажилчдын ирцийн үзүүлэлтээр шалгаруулан эхний 5 байр эзлүүлж шагнаж урамшууллаа.

Граунд гольфын Олон улсын нээлттэй тэмцээн 6-р сарын 29,30-ны өдрүүдэд Улаанбаатар хотод болж, 11 орны 472 тамирчин оролцжээ. Архангай аймаг багийн амжилтаар тэргүүн байр эзэлж, аваргын цом өргөмжлөл, хувийн амжилтаар эрэгтэйчүүдээс Ө.Бямбадорж 2-р байранд орж мөнгөн медаль, эмэгтэйчүүдээс Ч.Оюунгэрэл 2-р байранд орж мөнгөн медаль тус тус хүртлээ.

Аймгийн нийт тамирчдаас 6 тамирчин 7 алтан бөмбөгийн эзэн болж, тэмцээнийг тэргүүлснээр 2018 онд Ази тивийн анхны аварга, 2017, 2019 онуудад олон улсын нээлттэй тэмцээнд тус тус түрүүлж хошой аварга болсон байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр

2019 оны эхний хагас жилийн байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхитэй хайгч 1145 иргэн бүртгэлтэй байгаагаас 578 эмэгтэй, байнгын шинэ ажлын байр 537, түр ажлын байр 84, ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 547, зуучлал 523 байна. 6 сарын байдлаар 482 иргэн нь шинээр бүртгүүлж, LMIS програмд шивж оруулсан. Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр ангилвал: боловсролгүй- 13, бага-47, суурь-171, бүрэн дунд-689, техникийн болон мэргэжлийн анхан шатны – 31, тусгай мэргэжлийн дунд-18, Дипломын бакалврын-173, магистр-3 иргэнийг тус тус бүртгэж мэдээллийн бааз үүсгэн ажилласан байна. Шинэ ажлын байрыг эдийн засгийн салбараар нь ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 204, боловсруулах үйлдвэрлэлд 221, Бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт 25, бусад салбарт 87 ажлын байр шинээр бий болсон байна. Ажлын байранд зуучлагдан орсон иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилвал: Хөдөө аж ахуйн салбарт 199, боловсруулах үйлдвэрлэлд 23, барилга 16, үйлчилгээний болон бусад салбаруудад 285 иргэн зуучлагдан орсон байна. Тухайн онд ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн 8 иргэнийг LMIS програмд шивж оруулан тодорхойлолт гарган өгч Нийгмийн даатгалын хэлтэс рүү хүргүүлсэн.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх магадлан итгэмжлэгдсэн “Архангай бие даан амьдрах төв” ТББ-тай зөвлөгөө өгөх, “Архангай тэргэнцэртэй иргэдийн холбоо” ТББ-тай сургалт зохион байгуулах, “Хангай манба дацан”, “Очцо эрүүл мэндийн төв”, “Энхийн түүчээ” ХХК-тай сэргээн засах, “Бид танд тусална”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын зөвлөл” төрийн бус байгууллагуудтай гэрийн асрамж халамжийн үйлчилгээ “Архангай бие даан амьдрах төв” төрийн бус байгууллагатай өдрийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тус тус гэрээ байгуулан зорилтот бүлгийн 200 иргэнийг халамжийн үйлчилгээнд хамруулан ажиллаж байна.

Нийгмийн даатгалын санд 2019 оны 6 сарын байдлаар нийт 8 тэр бум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 117,6 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 14,4 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 22,01 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 3020,3 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд шилжүүлжээ.

Тухайн сард тэтгэврийн даатгалын санд 5278,2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, улсын төсвөөс 16600,0 сая төгрөгийг тэтгэврийн даатгалын санд хүлээн авсан. Тус сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 13,2 мянган иргэдийн тэтгэвэрт 21,1 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт 78 хувь буюу 16,6 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 10,1 мянган иргэнд зарцуулсан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлөөс “Хүүхэдтэйгээ ярилцъя-Хамтдаа шийдвэрлье” уриан дор “Хүүхдээ сонсоё” арга хэмжээг зохион байгууллаа. Эрдэнэбулган сумын 150 гаруй хүүхдүүд оролцож өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж,

Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүдээс тулгамдаж буй асуудлын талаар асууж тодруулсан байна.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн баярын арга хэмжээ Дэмид жанжны талбайд нээлтээ хийж, нээлтэд аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасан, Эрдэнэбулган сумын ИТХ-ын дарга Ш.Энхжаргал, Засаг дарга Ж.Гурвантамир нар оролцлоо. Хүүхдийн баярын энэ өдөр Эрдэнэбулган сумын ЗДТГ-аас хүүхдүүдийн дунд даам, дугуйн уралдаан, гүйлтийн тэмцээн, үндэсний бөхийн барилдаан, аха тэмцээн зэргийг зохион байгуулсан байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

Архангай аймгийн хэмжээнд 2019 онд 2.365.1 мянган толгой хээлтэгч мал төллөхөөс 6 дугаар сарын 25-ны байдлаар 1.989.862 мянган толгой мал төллөсөн байна. Үүнд: Ингэ 298 буюу 57,3 хувь, Гүү 90491 буюу 74.6 хувь, Үнээ 176080 буюу 73.4 хувь, Эм хонь 1173087 буюу 87.1 хувь, Эм ямаа 549906 буюу 83,6 хувь төллөж аймгийн дүнгээр бод малын 73,8 хувь, бог малын 86.0 хувь ба нийт мал төллөлт 84,1 хувьтай байна. 1926953 толгой төл 97 хувьтай бойжиж байна. Том малын зүй бус хорогдолор 41595 толгой мал нийт малын 0,7 хувь нь хорогдсон байна.

6 дугаар сарын 1,2-нд Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг гүйцэтгүүлэх гэрээг Цахир, Хангай, Чулуут, Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Хашаат зэрэг 7 сумын Засаг даргатай гэрээ байгуулж урьдчилгаа 70 хувийн санхүүжилтийг шилжүүлэв.

Засгийн Газраас хэрэгжүүлж байгаа “Мах, сүүний анхдугаар аян”, “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд өрхийн сүү үйлдвэрлэл, хүнсний зориулалтын сав, баглаа боодлыг дэмжих зорилгоор ХХААХҮЯ-аас Азийн Хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт” төслийн санхүүжилтээр нийт 92 сая төгрөгийн сүү боловсруулах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн иж бүрдлийг Чулуут, Тариат, Хангай, Өндөр-Улаан, Ихтамир сумдын 33 малчин, 3 хоршоонд олголоо.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Байгаль орчны чиглэлээр

БОАЖЯам, Аялал жуулчлалын ур чадварын сургуультай хамтран зохион байгуулж буй Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг 06 дугаар сарын 07 – оос 10 – ны өдрүүдэд Цэцэрлэг хотод өрөө, гэрийн үйлчлэгч, зочин хүлээн авагч, хаалгач, ачаа зөөгч, зөөгч, бариста, бартендер, аяллын тогооч, жолооч, хөтөч гэсэн 10 мэргэжлээр танхимын болон практикаар мэдлэг олгох хэлбэрээр зохион байгуулж, нийт 194 хүн хамрагдаж, гэрчилгээ олголоо.

Цэцэрлэг хотын Бөхбилэгт, Жамъян аварга, Барилгачдын болон Нутгийн захиргааны ордны баруун, зүүн, зүүн урд, өмнөх талын сад, Наран төвөөс 28 дугаар байр, цэцэрлэгт гудамж, Булган уулын дурсгалт газрын хамгаалалттай талбайд 6600 ширхэг мод, бут сөөгийг шинээр тарих, нөхөн тарилтын ажил, зүлэг тарих, цэцгийн мандал байгуулах ажлыг Цэцэрлэг мандал ар ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Мод үржүүлгийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дэргэдэх болон аймгийн Засаг даргын дэргэдэх сум дундын ойн ангийн Цэнхэр, Ихтамир, Эрдэнэмандал суман дахь мод үржүүлгийн газрын хөрс боловсруулалтын ажлыг технологийн дагуу хийж 7000 ширхэг улиасны тайрдас, хүлэмжинд 9 кг шинэс, 5 кг шар хуайс, 10 кг хайлаас, 3 кг гүйлс, 1 кг голт бор, 2 кг агчны үрийг тарьж, усалгаа, арчилгааны ажлыг тогтмол хийж гүйцэтгэж байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөс цаг агаарын урьдчилсан мэдээг өдөр бүр 12 цагаар болон нэг, тав хоногоор тус бүр 30 удаа нарийвчлан гаргаж, 7 хоногийн урьдчилсан төлвийг 5 удаа, сарын урьдчилсан төлөвийг 1 удаа гаргаж олон нийтийн сүлжээ болон телевиз, tsag-agaar.gov.mn сайтад өдөр бүр мэдээлж, байршуулсан..

Цаг агаарын байдал эрс өөрчлөгдөн цаашид хөдөө аж ахуйн болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахаар аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч болзошгүй “Урьдчилан анхааруулах мэдээ”-4, “Урьдчилан сэрэмжлүүлэх мэдээ” 1 удаа өгсөн.

Барилга, дэд бүтцийн чиглэлээр

2019 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 08 дугаар тогтоолоор аймгийн төсөвт газрын төлбөрөөс нийт 60000,0 мянган төгрөг төвлөрүүлэх ба эхний хагас жилийн байдлаар 30000,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 29478.4 мян.төг төвлөрсөн байна.

2019 онд Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 26.489.8 сая төгрөгийн өртөг бүхий 51 объектийн ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. Цахир сумын 320 хүүхдийн хичээлийн байр болон Батцэнгэл, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хайрхан, Цэцэрлэг, Эрдэнэмандал, сумдын оюутнуудын Улаанбаатар хотод баригдах дотуур байрны зургийн даалгаврыг боловсруулсан. Булган сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлыг “Гурван тамир” ХХК гүйцэтгэж 2019 оны 5-р сарын 28-ны өдөр, Ихтамир, Булган сумдад мал угаалгын ванн барих ажлыг “Би-Бор” ХХК гүйцэтгэж 2019 оны 6-р сарын 04-ний өдөр ашиглалтанд хүлээн авах комисс ажиллан байнгын ашиглалтанд хүлээн авсан.